

БАТЛАВ.

НИЙСЛЭЛИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН  
АЛБАНЫ ДАРГА  А.ЭНХМАНЛАЙ

**“ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ЗОРИУЛСАН ГАЗРЫН УДИРДЛАГЫН НЭГДСЭН  
ЦАХИМ СИСТЕМ НЭВТРҮҮЛЭХ”  
АЖЛЫН ДААЛГАВАР**

2020 оны 06 дугаар  
сарын 08 - ны өдөр

№ НТЗБ/ГМС-03 /2020 Улаанбаатар хот

Д/д	Ажлын нэр, төрөл	Тайлбар
1.	Ажил гүйцэтгэх үндэслэл	<ul style="list-style-type: none"><li>- Газрын тухай хууль;</li><li>- Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль;</li><li>- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 121 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” 2.81.12. “Газрын харилцааны талаар иргэдэд үзүүлэх үйлчилгээ, лавлагааны цахим системийг байгуулах”</li><li>- Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 47 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого /2017-2025/”</li></ul>
2.	Ажлын зорилго, шийдвэрлэх асуудал	Нийслэл хэмжээнд газрын цахим веб системийг нэвтрүүлэх.
3.	Хамрах хүрээ, талбайн хэмжээ	Багц 1. Иргэн, аж ахуйн нэгжид зориулсан веб систем, веб портал, байгууллагад зориулсан веб, мобайл аппликэйшин.
4.	Ажил гүйцэтгэх хугацаа	Нийслэл хэмжээнд газрын цахим веб системийг нэвтрүүлэх ажлын захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд гэрээ байгуулагдсан өдрөөс хойш нийт хугацаа 60 хоног байна.

5.	Ажлын иж бүрдэл	<ol style="list-style-type: none"> <li>1. Иргэн, аж ахуйн нэгжийн бүртгэл, эрх, хандалтыг зохицуулах модулийн хөгжүүлэх. Төрийн мэдээлэл солилцох ХУР системтэй холбох;</li> <li>2. Газрын удирдлагын системийн төлбөр татварын дэд системийг иргэд, аж ахуйн нэгжийн веб системтэй холбох модулийн хөгжүүлэлт;</li> <li>3. Газрын удирдлагын системийн кадастрын дэд системийг иргэд, аж ахуйн нэгжийн веб системтэй холбох модулийн хөгжүүлэлт;</li> <li>4. Газрын удирдлагын системийн Газар зохион байгуулалтын дэд системийг иргэд, аж ахуйн нэгжийн веб системтэй холбох модулийн хөгжүүлэлт;</li> <li>5. Газрын удирдлагын системд бүртгэлтэй өөрийн мэдээллээр нэвтрэх болон Төрийн мэдээлэл солилцох ХУР системийн тусламжтайгаар бүртгүүлэх;</li> <li>6. Хамтран ажиллагч байгууллагын таних, нэвтрэлтийн модуль хөгжүүлэх;</li> <li>7. Иргэн, аж ахуйн нэгжийн газрын лавлагааны модуль хөгжүүлэх;</li> <li>8. Газар зохион байгуулалтын албанд санал, хүсэлт илгээх модуль хөгжүүлэх;</li> <li>9. Өөрийн эрхийн харилцаанд орсон газрын бүх мэдээллийг харах боломжийг бүрдүүлэх;</li> <li>10. Шинээр газар эзэмших, ашиглах, өмчлөх хүсэлтийг Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнөөс сонгон өгөх боломжийг бүрдүүлэх;</li> <li>11. Хүсэлт өгсөн өргөдлийн явцыг веб порталаар дамжуулах хянах, санал өгөх боломжийг бүрдүүлэх;</li> <li>12. Цахим архивтай холбогдон өөрийн цахим файлыг хэвлэн авах боломжийг бүрдүүлэх. (Захирамж, кадастрын зураг...);</li> <li>13. Бүх төрлийн лавлагааг QRCode - н хамтаар хэвлэн авах боломжийг бүрдүүлэх;</li> <li>14. Бүх төрлийн газрын татвар, төлбөр, хураамжийг вебээр дамжуулан төлөх боломжийг бүрдүүлэх;</li> <li>15. Гар утсанд иргэн, аж ахуйн нэгжийн таних модуль хөгжүүлэх;</li> <li>16. Өөрийн эрхийн харилцаанд орсон газруудын дэлгэрэнгүй мэдээлэл харах модуль хөгжүүлэх;</li> <li>17. Өргөдөл шийдвэрлэлтийн хянах болон санал өгөх модуль хөгжүүлэх;</li> <li>18. Газрын татвар, төлбөр, хураамжаа харах болон төлөх модуль хөгжүүлэх;</li> <li>19. Шинээр газар эзэмших, ашиглах, өмчлөх хүсэлтийг Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнөөс сонгон өгөх модуль хөгжүүлэх;</li> <li>20. Газрын лавлагааг утсан дээр авах болон шалгах модуль хөгжүүлэх;</li> <li>21. Газрын зөрчил маргааныг илгээх, шийдвэрлүүлэх модуль хөгжүүлэх;</li> <li>22. Газрын үнэлгээ татварын мэдээллийг харах, шинээр зурж тооцоолох модуль хөгжүүлэх;</li> <li>23. Бусад системүүдтэй холбогдон мэдээлэл харах,</li> </ol>
----	-----------------	--

		илгээх модуль хөгжүүлэх (Бирж, Киоск).
6.	Ажлын үр дүн	Ажлын иж бүрдэл заасан ажил бүрэн хийгдэж гар утасны аппликэйшин болон цахим веб систем бий болно. Иргэн, аж ахуйн нэгжид зориулсан веб систем, веб портал, байгууллагад зориулсан веб систем болон мобайл аппликэйшин хэрэглээнд гарсан байна.
7.	Техникийн шаардлага	<ul style="list-style-type: none"> <li>- Захиалагч байгууллагаас баталсан ажлын удирдамж болон ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баримтлах;</li> <li>- Газар зүйн мэдээллийн системийн нээлттэй эх үүсвэрийн програм хангамжийг ашиглах;</li> <li>- Газрын кадастрын мэдээллийн сангийн нээлттэй эх үүсвэрийн програм хангамжийн хөгжүүлэлтийг хийх боломжтой, өмнө нь ижил төстэй ажил үйлчилгээ хийж байсан байх;</li> <li>- Системийг нээлттэй эх үүсгэвэрийн өгөгдлийн сангийн удирдлага бүхий орчинд бүрдүүлсэн байх;</li> <li>- Газрын кадастрын мэдээллийн сангийн Лэнд менежер програм хангамжид суурилсан байх;</li> <li>- Мэдээллийн чанар орон зайн мэдээллийн дэд бүтцийн өгөгдлийн стандарт шаардлагыг хангасан байх;</li> <li>- Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн системд агуулагдах үндсэн элементүүдэд үндэслэсэн байх, орон зайн өгөгдлийн стандарт шаардлагыг хангасан байх;</li> <li>- Хэрэглэгчийн болон удирдлагын түвшинд сургалт зохион байгуулж боловсон хүчнийг чадавхжуулсан байх;</li> <li>- Цаашид нэмэлт хөгжүүлэлт хийх боломжтой байх.</li> </ul>
8.	Ажлын хяналт, шалгалт	Захиалагчийн хяналтыг Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар, Нийслэлийн Газар зохион байгуулалт алба хамтран гүйцэтгэнэ.
9.	Баримтын төвд хүлээлгэн өгөх материал	<ul style="list-style-type: none"> <li>- Ажил гүйцэтгэсэн дэлгэрэнгүй тайлан тоон болон хэвлэмэл байдлаар;</li> <li>- Мэдээллийн сан, програм хангамжийн эх код, програм хангамжийн баримт бичиг;</li> <li>- Гар утасны аппликэйшин;</li> <li>- Цахим веб систем;</li> <li>- Техникийн болон системийн бичиг баримт</li> <li>- Захиалагчийн техникийн хяналтын дүгнэлтийг ажлын</li> </ul>

		гүйцэтгэл болон цаасан болон CD, DVD-д бичиж тус бүр 3 хувийг актаар хүлээлгэн өгөх.
10.	Захиалагч байгууллага	Нийслэлийн Газар зохион байгуулалт алба
11.	Гүйцэтгэгч байгууллага	Орон зайн мэдээллийн системийн програм хангамжийн хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг туршлагатай, өмнө энэ асуудлаар ижил төстэй ажил гүйцэтгэж байсан хуулийн этгээд гүйцэтгэнэ,
12.	Санхүүжилт, эх үүсвэр	140.0 сая төгрөг;
13	Төрийн нууцыг хадгалах, хамгаалах	Төрийн болон албаны нууцын тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад журам, зааврын дагуу төрийн нууцыг хадгалах, хамгаалах ажлыг зохион байгуулна.
14	Даалгаварт тусгагдаагүй ажил	Даалгаварт тусгагдаагүй ажлыг нэмэлт нөхцөлөөр гүйцэтгэж болох ба үүнийг гэрээний тусгай нөхцөлөөр тодорхойлно.


**ХЯНАСАН:**

НИЙСЛЭЛИЙН ГАЗАР ЗОХИОН  
БАЙГУУЛАЛТЫН АЛБАНЫ  
ГАЗРЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

 / Д.НЯМДАВАА /

**БОЛОВСРУУЛСАН:**

НИЙСЛЭЛИЙН ГАЗАР ЗОХИОН  
БАЙГУУЛАЛТЫН АЛБАНЫ  
ГАЗРЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН  
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

 / Э.ЭНХЦОЛМОН /